



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Улаанбаатар хотноо 2019 оны 3 сард

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/03



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**3 сар
2019**



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР	4
1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	16
1.1 Хүн ам.....	16
1.2 ЭРҮҮЛ МЭНД	17
1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	24
1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ.....	26
1.5 ГЭМТ ХЭРЭГ.....	Error! Bookmark not defined.
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	29
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ	29
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР	31
2.3 ГАДААД ХУДАЛДАА	35
2.4 ҮНЭ	35
3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	38
3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	38
3.2 АЖ ҮЙЛДВЭР	Error! Bookmark not defined.

**Ерөнхий тэмдэглэл**

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
- ГХ- Гэмт хэрэг
 - Х.н-Хэмжих нэгж
 - ХАА- Хөдөө аж ахуй
 - АҮ - Аж үйлдвэр
 - ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
 - СЭ - Сэлэнгэ
 - НХ – Нийгмийн халамж
 - ХЧТА-Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
 - ЖА-Жирэмсний амралт
 - ҮОМШӨ-Үйлдэрийн осол мэргэжлээс шалгаалах өвчин
 - НӨАТ-Нэмэгдсэн өртгийн албан татвар
 - ҮХЭХӨЭ- Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх
 - ГӨЭ-Газар өмчлөх эрх
 - ШША-Шүүхийн шинжилгээний алба
 - ШШГГ-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
 - НДШ-Нийгмийн даатгалын шимтгэл
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
- ... Мэдээлэл байхгүй
 - Х Бүтцийн өөрчлөлт
 - 0.0 Маш бага тоо
 - +, - Зөрүү
 - Гүйцэтгэл байхгүй
 - * Дахин
- "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Төсөв: Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Ажилгүйчүүд: Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

Бүртгэлтэй ажилгүй иргэд: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал: нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчид тооцно.

Үнэ: Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс: Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.



Гэмт хэрэг: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

Хээлтэгч мал: Нас гүйцсэн эм малыг хамруулна.

Зүй бусаар хорогдсон малын тоонд: Халдвартай , халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Аж үйлдвэр: Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**

(2019 оны эхний 3 сарын байдлаар)

1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**1.1 Хүн ам**


2019 оны эхний 3 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 851 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 50.9 хувь нь эрэгтэйчүүд, 49.1 хувь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүд 2.7 хувиар, эмэгтэйчүүд 11.4 хувиар буурсан байна.

**1.2 Эрүүл мэнд**

Эхний 3 сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 440 эх төрж, 443 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 3.3 хувиар өссөн байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 141 буюу 32.0 хувь, 20-24 насны 95 буюу 21.6 хувь, 30-34 насны 114 буюу 25.9 хувь, 35-39 насны 59 буюу 13.4 хувь, 40-44 насны 6 буюу 1.4 хувь, 20 хүртэлх насны 25 буюу 5.7 хувийг тус тус эзэлж байна.

Нас барсан хүний тоо 118 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 16 хүнээр буюу 11.9 хувиар буурсан байна. 0-1 насны хүртэлх хүүхдийн эндэгдэл 2, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын шалтгааны 13.6 хувь нь осол гэмтлийн, 20.3 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна. Хорт хавдрын өвчнөөр өвчлөгсөд өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өсч, хорт хавдрын өвчлөлийн нас баралт 33.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эхний 3 сарын байдлаар 631 жирэмсэн шинээр хяналтанд орсны 83.7 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан байна. Шинээр хяналтанд авсан жирэмсний 91.4 хувийг цусны шинжилгээнд хамруулснаас 44.8 хувьд нь сум, тосгодын эмнэлэгүүдэд гемоглобины тестээр шинжилсэн ба шинжилгээнд орсон 631 жирэмсний 1.0 хувьд нь цус багадалт илэрчээ.



Халдварт өвчнөөр 175 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 38.6 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчний 60.0 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 24.0 хувийг сүрьеэ, 16.0 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.




2019 оны эхний 3 сард нийт 96 454 үзлэг хийсний 21.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 9.5 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 13.2 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 9 709 дуудлаганд үйлчилсний 13.1 хувийг алсын дуудлагаар үйлчилж яралтай тусламж үзүүлсэн.



1.3 Хөдөлмөр

2019 оны 1-р улирлын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 760 болсон нь өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 50.7 хувийг ерөнхий боловсролтой, 22.9 хувийг дээд боловсролтой, 20.5 хувийг мэргэжилтэй ажилчид, 5.0 хувийг тусгай дунд боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 47 хүн ажилд зуучлагдан орж, 157 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 211 хүн шинээр бүртгэгдсэн байна. Шинээр 72 ажлын байр бий болж хөдөө аж ахуй, ан агнуур ой аж ахуй загас агнуур 11.1 хувь, боловсруулах үйлдвэр, худалдаа гэр ахуйн засвар үйлчилгээ, боловсролын салбар тус тус 34.7 хувийг эзлэж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролоор



1.4 Нийгмийн даатгал, халамж

2019 оны 1-р улирлын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16 670 тэтгэвэр авагчдад 17 498.2 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 1 891 хүнд 784.9 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулга, өвчтөн сахисны тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 223 хүнд 503.6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 137 хүнд 222.3 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 33 200 хүнд 4 328.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая.төг



**1.5 Хүүхэд, гэр бүл, биеийн тамир спорт**

2019 оны 1-р улирлын байдлаар хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 17, хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 20 байна.

Гэр бүлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн сургалт 1, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн иргэд 3 байна.

Хүүхдийн хөгжил оролцооны чиглэлээр багачуудын дунд хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр зохиосон 3 удаагийн арга хэмжээнд 493 хүүхэд хамрагджээ. Улсын чанартай уралдаан тэмцээнээс 20 хүүхэд медаль авчээ.

**1.5 Гэмт хэрэг**

2019 оны 1-р улирлын байдлаар нийт 221 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 45.4 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн 14.5 хувь нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.8 хувиар буурсан байна.


Иргэн болон байгууллагад нийт 554.6 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 412.5 сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлоос 142.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 25.7 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 38.9 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 32.1 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 14.5 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 6.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 8.2 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

**1.6 Хилээр орсон, гарсан иргэд**


Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 151 123 зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеээс 4.7 хувиар өссөн байна. Нийт зорчигчдын 83.5 хувь нь Монгол иргэд, 16.5 хувь нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 5.1 хувиар, гадаад иргэдийн тоо 3.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 7 159 хүн зорчсон байна.

Хилээр орсон гарсан иргэд


**2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ****2.1 Мөнгө, банк**

Монгол банкны мэдээгээр энэ сард кассын цэвэр орлого 41 549.7 сая төгрөг, цэвэр зарлага 42 787.3 сая төгрөгт хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл 319 462.2 сая төгрөг байгаа ба үүний 2.4 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 95 983.1 сая төгрөг байна.

Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум.төг/**2.2 Төрийн сан, татвар**

2019 оны 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 4 798.5 сая төгрөг буюу 89.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 3 722.3 сая төгрөг буюу 91.5 хувийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 1 076.1 сая төгрөг буюу 84.5 хувийн гүйцэтгэлтэй байна. 2019 оны 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 16 054.0 сая төгрөг буюу 81.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 4 060.6 сая төгрөг буюу 67.0 хувь, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 11 993.4 сая төгрөг буюу 88.4 хувийн гүйцэтгэлтэй байна. 3 сард нийт Сумдад 4 183.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 11 232.9 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 35.3 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 123.3 сая төгрөг буюу 82.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /сая.төг/


Татварын орлогын гүйцэтгэл 5 857.0 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 105.3 хувьтай байна. 2019 оны 1-р улиралд 57 аж ахуйн нэгж байгууллага шинээр бүртгэгдэж, 3 аж ахуйн нэгж байгууллага татан буугдан, нийт 3 782 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна. 2019 оны 3 сарын байдлаар татвар төлөгч иргэд цахим төлбөрийн баримтын системд 3 удаагийн сугалааны тохирлоор улсын хэмжээнд нийт 20 756 иргэн азтан тодорч, 1 011.7 сая төгрөгийн сугалааны урамшууллын тохирол таарсан байна.



2.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2019 оны эхний 3 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 60.9 сая ам доллар, үүнээс экспорт 1.5 сая ам доллар, импорт 59.4 сая ам доллар байна.

Гадаад худалдааны бараа эргэлт, сая\$




2.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2019 оны эхний 3 сард өмнөх сараас 0.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар тус тус өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 6.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 6.6 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 2.4 хувь, орон сууц ус цахилгаан хийн болон бусад түлш 2.3 хувь, тээвэр 2.3 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 1.2 хувь, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ 1.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувь



Малын үнэ 2018 оны мөн үеэс 90.000-1.00.000 төгрөгөөр өссөн байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны шир 5.000 төгрөг буюу 50 хувиар, үхрийн шир 20.000 төгрөг буюу 5 дахин, хонины нэхий 1.500 төгрөг буюу 4 дахин тус тус буурсан байна.



3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ




3.1 Хөдөө аж ахуй

2019 оны эхний 3 сарын байдлаар 202.2 мянган эх мал төллөсөн нь урьд оны мөн үеэс 29.1 мянган толгой буюу 16.8 хувиар нэмэгдсэн байна. Мал төллөлтийн хувь Жавхлант, Баруунбүрэн, Зүүнбүрэн сумдад өндөр буюу 48.2-58.1 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 201.3 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 29.6 мянган толгой буюу 17.3 хувиар их байна.

2019 оны эхний 3 сарын байдлаар оны эхний нийт малын 0.1 хувьтай тэнцэх 1176 толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 5.1 дахин бага байна. Хорогдсон нийт малын 0.7 хувийг өвчнөөр хорогдсон, 31.4 хувь нь хээлтэгч малын хорогдол байна. Хорогдсон нийт малын 474 толгой буюу 40.3 хувь нь Баруунбүрэн, Цагааннуур сумдад ногдож байна.

Төл бойжилт /мян.толгой/




3.2 Аж үйлдвэр

2019 оны эхний 3 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 58.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 102.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 99.2 хувиар буюу 29 258.9 сая.төгрөгөөр, борлуулалт 32.5 хувиар буюу 25 179.5 сая.төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 39.1 хувь нь уул уурхайн салбарт, 42.9 хувь нь хүнсний салбарт 10.7 хувь нь барилгын материалын салбарт, 7.3 хувь нь бусад салбарт бүтээгджээ. Сумдын жижиг, дунд үйлдвэрүүд аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.3 хувьтай тэнцэх 172.9 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 0.2 хувьтай тэнцэх 180.3 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум. төг)





4. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



4.1 Цаг уур орчны мэдээ

ТАНЫ АНХААРАЛД

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур болон орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн **4 бүс** нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах, хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн **30 хувиас** хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд “зарим газраар”, **30-70 хувьд** “ихэнх нутгаар”, **70 хувиас дээш** нутгийг хамрах тохиолдолд “бүх нутгаар” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур **00**-аас бага болж хүйтрэхийг “цочир хүйтрэл” гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээр аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд “Урьдчилан анхааруулах мэдээ”, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин ноцтой бэрхшээл учруулж эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гаргаж “Харанга” дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад яаралтай хүргэдэг. Засаг дарга нар “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харъяа нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаархи мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газарт, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор тус тус ирүүлнэ. Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаархи мэдээллийг Улаанбаатар хотын 326606, **326609** утсаар өгөх юмуу “УБ-46, Жуулчны гудамж-5, Ус цаг уурын хүрээлэнгийн “Урьдчилан мэдээлэх секторт” гэсэн хаягаар ирүүлнэ.

Уур амьсгалын тойм

Climate review

Дөрөвдүгээр сарын агаарын температурын дундаж нь 1981-2010 оны дунджаар нутгаар 3-5 градус дулаан байдаг. Гэхдээ жил бүр адил байдаггүй. Тухайлбал, сүүлийн жилүүдийн байдлаар 1997-1999, 2004 онд дээрх дунджаас 3-5 градусаар, 2000, 2001, 2005, 2007, 2008, 2009, 2014, 2015, 2017 онд 1-6 градусаар дулаан байж, өдөртөө 16-21 хүрч дулаарч байсан бол 1991, 1993, 1995, 2010 онуудад ихэнх нутгаар, 2006, 2013 онд нутгийн зүүн хагаст уг дунджаас 1-5 градусаар хүйтэн байв.



1981-2010 оны дунджаар бүх сумдын нутгаар 4-9 мм хур тунадас ордог. Гэхдээ зарим жил уур амьсгалын дунджаас хэд дахин их буюу бага хур тунадас орох тохиолдол цөөнгүй байдаг. Тухайлбал, 1993, 1996, 1997, 2004 онуудад ихэнх сумдын нутгаар дунджаас харьцангуй бага хур тунадас орж, хуурайшилт ихтэй байсан бол 1998, 2002, 2003, 2013-2015 онд зарим нутгаар уур амьсгалын дунджаас 2 дахин их хур тунадас оржээ. Салхи 15 м/с-ээс давж шуурах нь тухайн сард дунджаар 3-5 удаа тохиолддог ч зарим жил 6-8 удаа ажиглагддаг.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Weather forecast

Энэ сарын агаарын дундаж температур нь бүх сумдын нутгаар уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан буюу 4-6 градус дулаан байх төлөвтэй.(1 дүгээр зураг).



Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үе, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Харин хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн сүүлийн хагаст шөнөдөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө Орхон, Сэлэнгийн хөндийгөөр 18-23 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан, Орхон-Сэлэнгийн саваар 12-17 градус дулаан байна.

Энэ сард бүх сумдын нутгаар уур амьсгалын дунджийн орчим буюу 4-9 мм хур тунадас орох төлөвтэй.(2 дугаар зураг).

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёр, гуравдугаар арав хоногийн сүүлчээр **ихэнх сумдын нутгаар**, нэг, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр, гуравдугаар арав хоногийн дунд үеэр **зарим сумдын нутгаар** хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр ихэнх сумдын нутгаар 14-16 м/с, нутгийн өмнөд хэсгээр түр зуур 18-20 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.

04-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

04-р сарын хур тунадасны урьдчилсан мэдээ





5. БУСАД

а . Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2019 оны эхний 3 сарын байдлаар 430 аж ахуйн нэгж байгууллага, 65 иргэнд хяналт, шалгалт хийж, 1341 зөрчил дутагдал илрүүлж, 251 зөрчил арилгуулсан байна.

2019 оны 1-р улиралд Санхүү хяналт, аудитын алба нийт 3 аж ахуй нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж, 21 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж өгч ажилласан байна. Санхүү төсвийн чиглэлээр 1 удаа сургалт явуулж 8 хүн хамруулсан байна.

б. Онцгой байдлын газрын мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 113 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны эхний 3 сарын байдлаар объектод 35, ой хээрийн 1 гал түймэр гарч 322.0 сая төгрөгийн хохирол учирсан байна.

в. Улсын бүртгэлийн хэлтэс

2019 оны 1-р улиралд Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээгээр төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийн баталгаажуулалтыг 4 иргэн, газраас бусад ҮХЭХЭ-н анхны бүртгэл, баталгаажуулалтыг 185 иргэн баталгаажуулж 1 гэмтээсэн гэрчилгээг, 1 үрэгдүүлсэн гэрчилгээг тус тус шинээр олгож, 73 иргэн лавалгаа, хуулбар хийлгэж, нийт 431 гэрчилгээ бичигдсэн байна. Мөн Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээгээр 1 912 мэдүүлэг хүлээн авч, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг 434 иргэн баталгаажуулсан байна. Өмчлөх эрх шилжих гэрээ 192 хийгдсэнээс худалдах, худалдан авах гэрээ 102, бэлэглэх гэрээ 46, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөх гэрээ 21 хийгдэж, 6 үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгож нийт 676 гэрчилгээ бичигдсэн байна. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны 1-р улиралд нийт үйлчилгээний хураамж 39 013.2 сая төгрөг, ҮХЭХӨЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 38 547.8 сая төгрөг төвлөрсөн байна.

г. Стандарт хэмжил зүйн хэлтэс

2019 оны 1 дүгээр улиралд 263 хэмжих хэрэгсэл баталгаажуулснаас механик 131, цахилгаан 55, эзэлхүүн 58, дулаан даралт 19 хэмжих хэрэгсэл байна. Үйлчилгээний гэрчилгээ 37 олгосон байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 4 итгэмжлэгдсэн лабораториор иргэд, аж ахуйн нэгж стандартын салбар сангаар үйлчлүүлсэн байна.

д. ШҮҮХ, ШШГАлба, ШШАлба

Сум дундын 20-р шүүхийн мэдээгээр 1-р улирлын байдлаар 187 хэрэг шийдвэрлэсэнээс 53 нь эрүүгийн хэрэг, 128 нь иргэний хэрэг, 6 нь захиргааны хэрэг байна. Он гараад бүгд 62 хүн ял шийтгүүлж, 32 хүн хорих ял шийтгүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд оны эхний үлдэгдэл 398 гүйцэтгэлийн материал байсан бөгөөд эхний 3 сарын байдлаар 145 материал нэмэгдэж, 20 материал хасагдсан



бүгд 520 гүйцэтгэлийн материалаар 4852.7 сая төгрөгийн өрийг барагдуулахаас 93 гүйцэтгэлийн материалаар 333.8 сая төгрөгийн өрийг бодитой барагдуулжээ.

ШША-ны криминалистик шинжээч нар бүгд 16 шинжилгээ хийж, 118 хэргийн газарт үзлэг хийхэд оролцсон байна. Шүүхийн шинжилгээний эмнэлэг нь эхний 3 сарын байдлаар хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 134, цогцост шинжилгээ 40, эксгумацци хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээ 1, хүний биед хийсэн бусад үзлэг 20 байна.


е. Түүвэр судалгаа

2019 оны 1-р улирлын байдлаар өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 102 өрхөөс, ажиллах хүчний судалгааг 160 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 990.0 мянган төгрөг олгосон байна.

**1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 Хүн ам****1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумаар**

Сумын нэр	2016-III	2017-III	2018-III		2019-III	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	521	484	917	472	851	418
Алтанбулаг	21	21	23	16	13	6
Ерөө	23	39	40	20	37	15
Зүүнбүрэн	17	17	26	9	19	8
Мандал	116	90	412	234	297	145
Орхон	9	10	8	3	13	6
Сант	12	11	29	13	25	12
Цагааннуур	22	13	21	9	38	21
Баянгол	20	29	55	28	55	25
Сайхан	44	55	46	17	127	59
Орхонтуул	23	16	22	14	36	20
Баруунбүрэн	21	14	11	5	29	16
Шаамар	14	36	19	8	33	18
Хүдэр	12	12	19	7	24	9
Сүхбаатар	114	96	153	75	64	39
Жавхлант	23	12	5	2	14	6
Түшиг	19	2	11	4	16	8
Хушаат	11	11	17	8	11	5

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Шилжин ирсэн иргэдийн тоо

**1.2 ЭРҮҮЛ МЭНД****1.2.1 ТӨРӨЛТ**

Сумын нэр	Төрсөн эх				<u>2019 - III</u> <u>2018 - III</u>
	2016 - III	2017- III	2018 - III	2019 - III	
ДҮН	470	392	426	440	103.3
Алтанбулаг		1	1		
Ерөө	13	4	10	11	110.0
Зүүнбүрэн	1		3	1	33.3
Мандал	161	136	157	151	96.2
Орхон					
Сант					
Цагааннуур	1	6	5	2	40.0
Баянгол		2	1		
Сайхан	35	19	15	23	153.3
Орхонтуул	5	1	4		
Баруунбүрэн	2		1	1	100.0
Шаамар	1	1	2		
Хүдэр		1	1		
Сүхбаатар	240	218	220	246	111.8
Жавхлант		1			
Түшиг	8	2	5	5	100.0
Хушаат	3		1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.2 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО

Сумын нэр	амьд төрсөн хүүхэд								<u>2019 - III</u> <u>2018 - III</u>
	2016 - III		2017 - III		2018 - III		2019 - III		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	471	211	392	237	426	197	443	214	104.0
Алтанбулаг			1	1	1				
Ерөө	13	7	4	3	10	6	12	4	120.0
Зүүнбүрэн	1				3		1		33.3
Мандал	163	71	137	86	157	78	152	77	96.8
Орхон									
Сант									
Цагааннуур	1		5	3	5	3	2	1	40.0
Баянгол			2	1	1				
Сайхан	35	19	19	12	15	6	24	12	160.0
Орхонтуул	5	3	1	1	4				
Баруунбүрэн	2	1			1	1	1		100.0
Шаамар	1		1		2				
Хүдэр			1	1	1				
Сүхбаатар	239	106	218	128	220	99	246	117	111.8
Жавхлант			1	1					
Түшиг	8	4	2		5	4	5	3	100.0
Хушаат	3				1				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.3 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

Сумын нэр	0-1 насны хүртэлх хүүхэд			
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III
Дүн	17	2	6	2
Алтанбулаг				
Ерөө	1			
Зүүнбүрэн			1	
Мандал	3			
Орхон				
Сант				
Цагааннуур	1	1		
Баянгол				
Сайхан	1		1	
Орхонтуул				
Баруунбүрэн	1			
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	9	1	4	2
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III
Дүн	3	2	1	1
Алтанбулаг				
Ерөө		1		
Зүүнбүрэн				
Мандал		1		
Орхон				
Сант	1			
Цагааннуур				
Баянгол				
Сайхан				1
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар	2		1	
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.4 НАС БАРАЛТ**

Сумын нэр	нас баралт								2019 - III 2018 - III
	2016 - III		2017 - III		2018 - III		2019 - III		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	146	63	125	48	134	47	118	36	88.1
Алтанбулаг	5	4	5	2	5	3	9	1	180.0
Ерөө	10	3	10	2	13	4	6	2	46.2
Зүүнбүрэн	5	2	2	1	1		5	1	5.0*
Мандал	34	13	36	13	44	17	28	11	63.6
Орхон	2	2	3	2	2		1		50.0
Сант	2	1	2	1			2		
Цагааннуур	4	1	5	1	5	3	2	1	40.0
Баянгол	9	3	3	2	3	1	5		166.7
Сайхан	13	7	11	3	15	5	8	2	53.3
Орхонтуул	6	3	3	3	2		7	3	3.5*
Баруунбүрэн	5	1	4	3	2	2	5	4	2.5*
Шаамар	5	2	4	2	4	2	4	1	100.0
Хүдэр	4	1	1		1		2		2.0*
Сүхбаатар	36	15	33	12	32	9	30	9	93.8
Жавхланта	1		1		1		1		100.0
Түшиг	2	2			4	1			
Хушаат	3	3	2	1			3	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.5 НАС БАРАЛТ, насны бүлгээр

Үзүүлэлт	2016 -III	2017 - III	2018 - III	2019 - III	2019 – III 2018 – III
Бүгд	146	125	134	118	88.1
эмэгтэй	63	48	47	36	76.6
0 - 1	17	2	6	2	33.3
1 - 5	3	1	1	1	100.0
6 - 18	5	4		2	
19 - 54	43	35	42	35	83.3
54-с дээш	78	83	85	78	91.8

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.6 ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛИЙН НАС БАРАЛТ**

Сумын нэр	Нас баралт								$\frac{2019 - III}{2018 - III}$
	2016 - III		2017 - III		2018 - III		2019 - III		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	30	10	31	9	36	8	24	9	66.7
Алтанбулаг	3	1	2				2		
Ерөө	1				1		1		100.0
Зүүнбүрэн	1				1		2	1	2.0*
Мандал	7	4	10	2	11	4	10	5	90.9
Орхон									
Сант	1								
Цагааннуур			1		1				
Баянгол	2	1					1		
Сайхан	2		5	2	6	1	1		16.7
Орхонтуул	3	1					1	1	
Баруунбүрэн	3	1	1				1	1	
Шаамар	2	1	2	1	2		1		50.0
Хүдэр	1		1		1				
Сүхбаатар	2	1	9	4	12	3	3	1	25.0
Жавхлант	1						1		
Түшиг					1				
Хушаат	1								

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.7 ХОРТ ХАВДРЫН ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД

Сумын нэр	Хорт хавдрын өвчин								$\frac{2019 - III}{2018 - III}$
	2016 - III		2017 - III		2018 - III		2019 - III		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	33	19	31	18	37	23	76	35	2.0*
Алтанбулаг	3	3			5	4	4	3	80.0
Ерөө	1				2	2	4	2	2.0*
Зүүнбүрэн	1	1			2		3	1	150.0
Мандал	3	2	5	3	6	4	13	6	2.1*
Орхон	1						3	1	
Сант	1						1		
Цагааннуур	3	1	4	2	1		2	1	2.0*
Баянгол	4	2			2	1	3		150.0
Сайхан	2	1	6	4	5	2	8	6	160.0
Орхонтуул	2	2			1	1			
Баруунбүрэн	2	1	1	1	1	1	1	1	100.0
Шаамар	1	1			3	2	3	2	100.0
Хүдэр	1		3	1					
Сүхбаатар	3	1	9	5	8	5	25	7	3.1*
Жавхлант	2	2					2	1	
Түшиг	2	1	3	2	1	1	2	2	2.0*
Хушаат	1	1					2	2	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.8 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Бүх халдварт өвчин				<u>2019 - III</u> 2018 - III
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	
ДҮН	1 054	162	285	175	61.4
Алтанбулаг	30	4	20	9	45.0
Ерөө	78	2	10	5	50.0
Зүүнбүрэн	19	16	5	3	60.0
Мандал	398	14	37	31	83.8
Орхон	5		9		
Сант	10	1			
Цагааннуур	50	7	13	8	61.5
Баянгол	18		28	6	21.4
Сайхан	51	12	29	7	24.1
Орхонтуул	3	2	3	4	133.3
Баруунбүрэн	19		2	2	100.0
Шаамар	30	18	7	6	85.7
Хүдэр	33		2		
Сүхбаатар	278	80	101	89	88.1
Жавхлант	12		4	1	25.0
Түшиг	5	5	14	2	14.3
Хушаат	15	1	1	2	2.0*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Бэлгийн замын өвчин				<u>2019 - III</u> 2018 - III
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	
ДҮН	119	85	206	105	51.0
Алтанбулаг	5	4	15	2	13.3
Ерөө	2	1	4	2	50.0
Зүүнбүрэн	3	4	5	2	40.0
Мандал	18	5	21	16	76.2
Орхон			9		
Сант		1			
Цагааннуур	5	4	12	7	58.3
Баянгол			22	2	9.1
Сайхан	4	5	27		
Орхонтуул	2		2	2	100.0
Баруунбүрэн	8			1	
Шаамар		7	6	6	100.0
Хүдэр	3		1		
Сүхбаатар	63	50	70	62	88.6
Жавхлант	1		1	1	100.0
Түшиг	2	4	11	1	9.1
Хушаат	3			1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	Гипатит				<u>2019 - III</u> 2018 - III
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	
ДҮН	2	0	2	0	0.0
Алтанбулаг			1		
Ерөө					
Зүүнбүрэн					
Мандал	2				
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул					
Баруунбүрэн					
Шаамар					
Хүдэр					
Сүхбаатар					
Жавхлант					
Түшиг					
Хушаат			1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Сүрьеэ				<u>2019 - III</u> 2018 - III
	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	
ДҮН	51	40	58	42	72.4
Алтанбулаг	5		3	5	166.7
Ерөө	2	1	6	3	50.0
Зүүнбүрэн	1			1	
Мандал	12	9	12	11	91.7
Орхон	2				
Сант	1				
Цагааннуур	3	3	1	1	100.0
Баянгол	5		6	4	66.7
Сайхан	4	4	2	3	150.0
Орхонтуул	1	2	1	2	2.0*
Баруунбүрэн			2	1	50.0
Шаамар	2		1		
Хүдэр	1		1		
Сүхбаатар	12	19	17	9	52.9
Жавхлант			3		
Түшиг		1	3	1	33.3
Хушаат		1		1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2.9 ТӨРСӨН ЭХ, боловсролоор**

Үзүүлэлт	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	<u>2019-III</u> <u>2018-III</u>
Бүгд	470	392	426	440	103.3
Дээд боловсрол	81	97	104	101	97.1
Мэргэжлийн болон техникийн боловсрол	21	18	18	22	122.2
Дунд боловсрол	330	250	284	291	102.5
Бага боловсрол	29	23	18	18	100.0
Боловсролгүй	9	4	2	8	4.0*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.10 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр

Үзүүлэлт	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	<u>2019-III</u> <u>2018-III</u>
Бүгд	470	392	426	440	103.3
20 хүртэлх	31	26	18	25	138.9
20 - 24	133	114	111	95	85.6
25 - 29	151	99	127	141	111.0
30 - 34	80	82	90	114	126.7
35 - 39	61	56	68	59	86.8
40 - 44	14	15	12	6	50.0
45 - 49					

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.2.11 ШИНЭЭР ХЯНАЛТАД ОРСОН ЖИРЭМСЭН ЭХИЙН ТОО

Сумын нэр	Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхийн тоо	Үүнээс эхний 3 сартайдаа хяналтанд орсон жирэмсэн эхийн тоо
Дүн	631	528
Алтанбулаг	23	22
Ерөө	46	36
Зүүнбүрэн	16	13
Мандал	191	161
Орхон	15	15
Сант	6	6
Цагааннуур	31	25
Баянгол	21	15
Сайхан	37	31
Орхонтуул	13	13
Баруунбүрэн	10	10
Шаамар	30	23
Хүдэр	14	14
Сүхбаатар	143	113
Жавхлант	14	14
Түшиг	10	9
Хушаат	11	8

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ****1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД**, боловсролоор, 1-р улирлын байдлаар

Үзүүлэлт	2016 - III	2017 - III	2018 - III	2019 - III	$\frac{2019 - III}{2018 - III}$
Бүгд	965	889	911	760	83.4
Эмэгтэй	477	437	479	349	72.9
Дээд	243	285	313	174	55.6
Тусгай дунд	76	58	74	38	51.4
Ерөнхий боловсролтой	507	413	382	385	100.8
Мэргэжилтэй ажилчид	134	127	137	156	113.9
Боловсролгүй	5	6	5	7	140.0

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО сумдаар, 1-р улирлын байдлаар

Сумын нэр	Сарын эхний ажилгүйчүүд	Тухайн сард хасагдсан		Нэмэгдсэн	Сарын эцэс
		Ажилд зуучлагдсан	Идэвхгүйн улмаас хасагдсан		
ДҮН	753	47	157	211	760
Алтанбулаг	49	1	12	2	38
Ерөө	25	4	6	51	66
Зүүнбүрэн	18		13		5
Мандал	111	2	23	28	114
Орхон	7	2		2	7
Сант	22	1	9	1	13
Цагааннуур	45	4	11	8	38
Баянгол	86	12	14	21	81
Сайхан	39	10		18	47
Орхонтуул	36	2	11	3	26
Баруунбүрэн					0
Шаамар	53		1	4	56
Хүдэр	22		10	3	15
Сүхбаатар	180		47	46	179
Жавхлант	3	4		4	3
Түшиг	51	4		19	66
Хушаат	6	1		1	6

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.3 ШИНЭ АЖЛЫН БАЙР**

	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
ДҮН	72	8	15	5			14	7	1	1		1	11	6	2	1
Алтанбулаг	3												2		1	
Ерөө	9	1	3										3	1		1
Зүүнбүрэн																
Мандал	15	2					11					1	1			
Орхон																
Сант	6	2											2	2		
Цагааннуур	1						1									
Баянгол	1		1													
Сайхан	8							5		1				2		
Орхонтуул																
Баруунбүрэн																
Шаамар	5			2				2								1
Хүдэр	2			2												
Сүхбаатар																
Жавхлант	2															2
Түшиг	16	3	11						1							1
Хушаат	4			1			2							1		

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.4 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ****1.4.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН, сая.төг**

Үйлчилгээний төрөл	Хүн	Мөнгөн дүн, сая.төг
Халамжийн тэтгэвэр	2 364	1 157.3
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2 776	488.7
Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	17	20.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		
Жирэмсэн эхчүүдэд олгосон мөнгөн тэтгэмж	1 306	102.6
Ахмад дайчин, алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	63	22.6
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгосон тусламж	8 437	1 109.1
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	1 997	91.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	237	41.1
Насны хишиг	4 464	351.1
Цалинтай ээж хөтөлбөр	5 352	731.8
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	219	59.3
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 968	153.3
Нийт	33 200	4 329.0

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.4.2 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, АВЛАГА, сумаар, сая.төг

Сумдын нэр	НДШ-ийн орлого			НДШ-ийн авлага		
	төл	гүй	хувь	а/а нэгж	төсөв	бүгд
ДҮН	8 885.9	9 219.2	103.8	8 044.5	152.1	8 196.6
Алтанбулаг	132.7	154.7	116.6	16.9		16.9
Ерөө	961.3	949.3	98.8	113.2	1.9	115.1
Зүүнбүрэн	92.8	92.5	99.7	10.5	1.0	11.5
Мандал	2 330.1	2 737.4	117.5	289.6	39.6	329.2
Орхон	60.7	70.6	116.2	5.6	0.8	6.5
Сант	70.7	83.0	117.4	12.2	0.9	13.2
Цагааннуур	291.4	211.6	72.6		17.1	17.1
Баянгол	192.9	198.7	103.0	169.4		169.4
Сайхан	1 413.7	781.4	55.3	5 727.0	8.7	5 735.7
Орхонтуул	70.7	130.7	184.8	4.9	2.0	6.8
Баруунбүрэн	112.4	123.6	110.0	67.8	3.7	71.5
Шаамар	152.0	188.1	123.8	1.3	1.8	3.0
Хүдэр	105.0	114.7	109.2	25.9	7.1	33.0
Сүхбаатар	2 639.8	3 118.2	118.1	1 318.1	56.6	1 374.7
Жавхланта	80.6	84.4	104.7	12.9	1.3	14.2
Түшиг	83.3	85.7	102.9	251.2	9.7	260.9
Хушаат	96.0	94.6	98.6	18.0		18.0

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс

**1.5 ХҮҮХЭД, ГЭР БҮЛ****1.5.1 ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

